



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/212

Арвайхээр сум

Улсын аварга шалгаруулах тэмцээн
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн 1.3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын волейболын холбооны нэрэмжит клубуудын аварга шалгаруулах тэмцээнийг Арвайхээр хотноо 2024 оны 04 дүгээр сарын 07-15-ны өдрүүдэд, Хүндийн өргөлтийн залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнийг 2024 оны 04 дүгээр сарын 19-21-ний өдрүүдэд, Пауэрлифтингийн өсвөр, залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнийг 2024 оны 04 дүгээр сарын 13-14-ний өдрүүдэд Арвайхээр хотноо тус тус зохион байгуулсугай.

2. Монголын волейболын холбооны нэрэмжит клубуудын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр, Хүндийн өргөлтийн залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг 2 дугаар, Пауэрлифтингийн өсвөр, залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тэмцээний бэлтгэл, зохион байгуулалт, аюулгүй байдлыг сайтар ханган ажиллахыг зохион байгуулах хорооны нарийн бичгийн дарга (Д.Алтанхүү, С.Төмөрсуурь, О.Түвшинтөгс) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



И. ДОРЖСҮРЭН

8224 11 0440

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар
сарын 12-ны өдрийн 12 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

МОНГОЛЫН ВОЛЕЙБОЛЫН ХОЛБООНЫ НЭРЭМЖИТ
КЛУБУУДЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Хорооны дарга: И. Доржсүрэн (аймгийн Засаг дарга)

Гишүүд:

О.Сумъяасүрэн (аймгийн Засаг даргын Орлогч)

Б.Сайнжаргал (аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлстийн дарга)

Ө.Жамдүдсансүм (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын
хүрээний агентлаг Биеийн тамир, спортын газрын дарга)

Г.Чимэддагва (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын
хүрээний агентлаг Цагдаагийн газрын дарга)

Д.Түмэнжаргал (аймгийн Хөгжимт драмын театрын дарга)

М. Дэлгэрсайхан (Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн
Захирагч)

Ш. Мөнхцэцэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын хэвлэл
мэдээллийн ажилтан)

Нарийн бичгийн дарга: Д.Алтанхүү (Монголын Волейболын холбооны тэргүүлэгч,
аймгийн Волейболын холбооны тэргүүн, Хашхан ХХК-ний
захирал)

Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар
сарын 03-ны өдрийн 11612 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт



**СПОРТЫН ДЭД МАСТЕР Л.БАТБААТАР АГСНЫ НЭРЭМЖИТ
ХҮНДИЙН ӨРГӨЛТИЙН ЗАЛУУЧУУДЫН УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ
ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**

Хорооны дарга: И.Доржсүрэн (аймгийн Засаг дарга)

Гишүүд: О.Сумъяасүрэн (аймгийн Засаг даргын Орлогч)

Б.Сайнжаргал (аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлстийн дарга)

Ө.Жамдүдсансүм (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын
хүрээний агентлаг Биеийн тамир, спортын газрын дарга)

А. Нямхүү (аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн
штабын дарга)


Г.Чимэддагва (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын
хүрээний агентлаг Цагдаагийн газрын дарга)

Д.Түмэнжаргал (аймгийн Хөгжимт драмын театрын дарга)

Ш.Мөнхцэцэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын хэвлэл
мэдээллийн ажилтан)

Нарийн бичгийн дарга: С.Төмөрсуурь (аймгийн Хүндийн өргөлтийн холбооны
гүйцэтгэх захирал)

Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар
сарын 22-ны өдрийн 4112 дугаар
захирамжийн 3 дугаар хавсралт



ПАУЭРЛИФТИНГИЙН ӨСВӨР, ЗАЛУУЧУУДЫН УЛСЫН АВАРГА
ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Хорооны дарга: О.Сумъяасүрэн (аймгийн Засаг даргын Орлогч)

Гишүүд:

- Б.Сайнжаргал (аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлстийн дарга)
- Ө.Жамдудсансүм (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын
хүрээний агентлаг Биеийн тамир, спортын газрын дарга)
- Г.Чимэддагва (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын
хүрээний агентлаг Цагдаагийн газрын дарга)
- Д.Түмэнжаргал (аймгийн Хөгжимт драмын театрын дарга)
- М.Дэлгэрсайхан (Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн Захирагч)
- Ш.Мөнхцэцэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын хэвлэл
мэдээллийн ажилтан)

Нарийн бичгийн дарга: О.Түвшинтөгс (аймгийн Пауэрлифтинг, фитнесийн нэгдсэн
холбооны тэргүүн)

-оОо-